# Оёдлын багаж хэрэгсэл хийх сав зохион бүтээх

6-р анги

# Төсөл



- Асуудал хэрэгцээг тодорхойлох
- Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх
- Дизайны шинэ санаа шийдэл гаргах
- Бүтээх хөгжүүлэх
- Үнэлэх үр дүнгээ танилцуулах

# Аюулгүй ажиллагааны дүрэм



- Оёж байх үед гэрэл эгц урдаас болон зүүн гар талаас туссан байх бөгөөд нүдний хараа хийж буй эдлэлээс 30-35 см зайтай байх нь тохиромжтой.
- Хайчийг тусгай уутанд хийж хадгалж хэвших ба хайчны амыг ангайлгаж тавьж болохгүй.
- Хайчийг бусдад дамжуулахдаа бариул талаар нь өгнө.
- Зүүг тусгай хатгуурт хатгаж хэвших ба сул задгай орхиж хувцсанд хатгаж болохгүй.
- Зүүг амандаа зууж болохгүй.

# Асуудал хэрэгцээг тодорхойлох



- Оёдлын багаж хэрэгслийг аюулгүй хадгалж явах зориулалтын уут сав зайлшгүй хэрэгцээтэй байдаг. Иймээс бид энэ төслийн ажлаараа оёдлын багаж хэрэгслийн гоёмсог савны загвар зохиож, энгийн болон чимэглэлийн гар оёдлуудаар оёж, чимэглэх болно.

# Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх














# Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх



| Сайн тал | Дутагдалтай тал | Яаж илүү гоё болгох вэ? |
|---|---|---|
| - Зай бага эзэлнэ.<br>- ..............................<br>- ...............................<br>- ...............................<br>- ...........................<br>- ............................. | - Чимэглэл байхгүй<br>- Товч утас гэх мэт жижиг зүйл хадгалж болохгүй<br>- ..................................<br>- ...................................<br>- .................................<br>- ............................... | - Уяа бүчний үзүүрт өнгийн шүр хийж чимэглэнэ.<br>- ...............................................<br>- ...............................................<br>- ...............................................<br>- .............................................. |

# Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх

- Үүнийг хэн хэрэглэх вэ?
- Үүнийг яаж хэрэглэх вэ?
- Олон янзаар хэрэглэж болох уу?
- Өмнө байдаг хэлбэр загвараас давуу тал нь юу вэ?



# Бүтээх хөгжүүлэх

- Хийх эдлэлийнхээ эсгүүрийн зургийг гаргаж, гар оёдлын төрлүүдээр эдлэлээ хийж, чимэглэж дуусгана.
- Загварын тайлбар:

Энэхүү зүүний хатгуур нь даашинзны загвартай, ном шиг хуудастай. Хуудас бүр өөр өөр өнгө, чимэглэлтэй. Хавтасны даашинзны бүслүүр хэсэгт тууз хадаж, номоо хаагаад урдаа цэцэглэн зангиддаг загвартай. Хуудсуудад зүү, хатгуур зүүгээ хатгаж хадгална.



- Материал: Өнгө өнгийн эсгийнцэр, өнгийн утас, чимэглэл
- Багаж хэрэгсэл: Гар оёдлын зүү, хайч, хуруувч





Баярлалаа

Амжилт хүсье!

# Үнэлэх үр дүнгээ танилцуулах

Өөрийн зохиосон загваруудад эдлэлд тавих 5 шаардлагын дагуу 1-5 оноо өгч өөрийгөө дүгнээрэй



| № | Эдлэлд тавих шаардлага | Загвар 1 | Загвар 2 | Загвар 3 |
|---|---|---|---|---|
| 1 | Зүү утас, товч гэх мэт жижиг зүйлийг гээгдэхээргүй хадгалах  боломжтой байх | yes | | |
| 2 | Цүнхэндээ хийж явахад тохиромжтой, авсаархан хэлбэр, хэмжээтэй байх | yes | | |
| 3 | Шинэлэг өвөрмөц загвар, дизайнтай байх | yes | | |